МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 14

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ӨМГӨӨЛӨГЧӨӨС ГАРГАСАН НИЙТ 92 ГОМДОЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЛЭЭ



Прокурорын байгууллага 2025 оны 03 дугаар сарын 06-наас 13-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 47 гомдол, хүсэлтийг шинээр хүлээн авч, нийт 224 гомдол, хүсэлтийг хяналаа

Хүлээн авсан гомдол, хүсэлтийн 4 нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгуулах тухай байгаа бол бусад нь эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байна.

Дээрх хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос ирүүлсэн 80 гомдол, хүсэлтийг байгууллага өөрөө шийдвэрлэж, 12 -г харьяаллын дагуу шилжүүлж, одоо 132 гомдол, хүсэлтийг хянаж байна.

Хүлээн авч, шийдвэрлэсэн гомдол хүсэлтээс эрүүгийн хэргийн хохирогч нараас 32, сэжигтэн яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нараас 44, зөрчлийн хэргийн хохирогч болон иргэний нэхэмжлэгч, хариуцагчаас тус бүр 1, бусад оролцогчоос 2 гомдол, хүсэлт ирсэн байна.

Мөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав, Мишээл салбар дахь

“Прокурорын байгууллагын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх төв”-үүд 3 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч харьяа прокурорын газарт нь шилжүүлэн, прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг 15 иргэнд өгч ажиллажээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1103